




ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. S&P 500 индексийн сагсанд багтдаг тансаг хэрэглээний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон мэдээлэл технологийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш өссөн бол ус, дулаан, цахилгаан хангамжийн салбарын компаниудын хувьцааны ханш буурчээ.

АНУ-ын Ерөнхийлөгч ноён Доналд Трамп Холбооны нөөцийн сангийн бодлогын хүүгээ нэмсэн явдалд тааламжтай хандахгүй байгаа талаар мэдээлснээр хөрөнгийн зах зээлд сөргөөр нөлөөлжээ.

Гүйцэтгэх захирлууд өөрийн удирдаж буй компанийн хувьцааг худалдан авах явдал ихсэн, сүүлийн 8 жилийн дээд түвшинд хүрчээ. Худалдааны маргааны асуудал тойрсон эерэг хүлээлтүүд нэмэгдэж байгаатай холбогдуулан хөрөнгийн зах зээлийн индексүүд өссөн байна.

Зул сарын баяр тохиолдуулан 11-р сараас эхэлсэн нийт худалдан авалт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5.1%-аар өссөн талаар 'MasterCard' байгууллага мэдээлэв. Ингэснээр АНУ-ын хэрэглээ болон жижиглэнгийн худалдааны түвшин нэмэгдсэн байна.

Европ: Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд ихээр хэлбэлзсэн ч бага зэргийн өсөлт үзүүлээ.

АНУ-ын Засгийн газрын үйл ажиллагаасанхүүжилтгүйн улмаас хэсэгчлэн саатаад байгаа билээ. Хөрөнгө оруулагчид энэ байдлыг шинэ он гартал үргэлжилнэ хэмээн үзжээ. Харин энэхүү хүлээлт нь Европын хөрөнгийн зах зээлд сөргөөр нөлөөлсөн байна.

Долоо хоногийн сүүлээр худалдааны маргааны эерэг хүлээлт болон АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индекс өссөнтэй холбоотойгоор Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд мөн адил өсч эхэлжээ.

Их Британийн Хөдөлмөрийн намын дарга Жереми Корбин тус улсын Ерөнхий сайд хатагтай Тереза Мэйг 'Brexit' хэлэлцээрийг яаравчлах зорилгоор Парламентын ээлжит бус хурлыг Зул сарын баяраас өмнө хуралдуулах хэрэгтэй хэмээн үзжээ.

Италийн Засгийн газрын Дээд танхим тус улсын 2019 оны төсвийг урьдчилан баталлаа.

Япон: Энэ долоо хоногт Японы хөрөнгийн зах зээлийн Nikkei 225 индекс 0.75%-аар буурсан үзүүлэлтэй байна.

Япон улсын Төв банк 2018 оны нэгдсэн тайландаа "Тус улсын хувьцааны ханш худалдааны маргааны нөлөөгөөр саарсан ч эдийн засаг цаашид тогтвортой өсөх хандлагатай байгаа"-г онцолжээ.

7-9 дүгээр сарын дотоодын нийт бүтээгдэхүүний үзүүлэлт энэ онд Японы эдийн засгийн өсөлтөөс хойш татсан байна. Үүнд байгалийн гамшиг голлон нөлөөлсөн хэмээн Японы Төв банк тайландаа дурджээ.

БНХАУ: БНХАУ-ын эдийн засгийн өсөлт урьдчилсан байдлаар 7 сар дараалан саарах төлөвтэй байна. Худалдааны маргааны улмаас дотоодод эрэлт буурч, үйлдвэрлэлийн үнийн индекс саарч байгаа аж.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,646.96	1.51% ▲
Dow Jones	АНУ	23,062.40	2.75% ▲
S&P 500	АНУ	2,485.74	2.86% ▲
Nasdaq	АНУ	6,584.52	3.97% ▲
S&P/TSX	Канад	14,222.00	2.06% ▲
FTSE 100	Их Британи	6,733.97	0.19% ▲
S&P/ASX 200	Австрали	5,654.30	3.41% ▲
Nikkei 225	Япон	20,014.77	-0.75% ▼
Hang Seng	Хонг Конг	25,504.20	-0.97% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	107.58
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	95.17
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	94.30
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	110.49
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.73
DBM' 2023	USD	7.250%	98.41
TDBM' 2020	USD	9.375%	104.19

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.520	0.02 ▲
Libor 3M	2.800	-0.02 ▼
Libor 6M	2.870	-0.03 ▼
Libor 1YR	3.010	-0.06 ▼
US 2YR Bond	2.516	-0.12 ▼
US 3YR Bond	2.495	-0.12 ▼
US 5YR Bond	2.555	-0.08 ▼
US 10YR Bond	2.718	-0.07 ▼

Валютын ханш /төг/

Валют	2018.12.28	Өөрчлөлт
USD	2,642.92	0.19% ▲
CNY	385.73	0.86% ▲
EUR	3,028.65	0.10% ▲
RUB	38.00	-2.14% ▼
KRW	2.37	0.42% ▲
JPY	23.94	0.97% ▲
CAD	1,942.61	-0.57% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,281.52	1.40% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	15.47	5.17% ▲
Зэс	USD/lb.	269.30	0.67% ▲
Нүүрс	USD/MT	101.60	-0.68% ▼
WTI газрын тос	USD/bbl.	46.23	0.37% ▲
Brent газрын тос	USD/bbl.	54.46	0.17% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	3.09	-18.47% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. XI	8.10%
Бодлогын хүү	2018. XI	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. XI	10.20%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. XI	12.20%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. XI	5.30%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. XI	17.30%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. XI	10.70%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар 42 компанийн 1,768.9 сая төгрөгийн 3,870,251 ширхэг хувьцаа, хоёрдогч зах зээлийн багцын арилжаагаар 2 компанийн 31.9 тэрбум төгрөгийн 12,457,961 ширхэг хувьцаа арилжигдав.


“Хай би ойл” /HBO/ компанийн хувьцаа 38.67%-аар буюу хамгийн ихээр өсч 45.9 төгрөгт хүрч хаагдсан бол “Шарын гол” /SHG/ компанийн хувьцаа 15.45%-аар буурч 1,801 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны зах зээл дээр нийт 430 ширхэг үнэт цаас 44.2 сая төгрөгөөр арилжаалагдсан байна.


12-р сарын 28-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,428.1 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,646.96 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.51%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2018 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	33,739.2
Зах зээлийн үнэлгээ	2,428,110.1

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,646.96	1.51% ▲
MSE I индекс	9,790.66	0.39% ▲
MSE II индекс	8,748.85	0.41% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
МИК Холдинг	2,005,073	31,326,814,790
Хөвсгөл алтан дуулга	791,223	756,602,524
ЛэндМН ББСБ	11,947,666	701,608,876
АПУ	428,546	254,458,725
Ард даатгал	193,149	141,610,126

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Хай би ойл	45.90	38.67% ▲
МИК Холдинг	12,990.00	26.12% ▲
Хасу-Мандал	5,750.00	15.00% ▲
УБ-БҮК	385.00	14.93% ▲
Ай түүлс	106.04	6.04% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Шарын гол	1,801.00	-15.45% ▼
Дөрвөн-Уул	1,300.00	-13.33% ▼
Ар Баянхангай	700.00	-12.50% ▼
Эрдэнэт авто зам	425.00	-11.46% ▼
Гутал	16,000.00	-5.88% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ти Ди Би Капитал	61,841,745,843
Голомт Капитал	1,672,739,264
Мирэ Эссет Секьюритис Монгол	1,417,968,690
Бумбат-Алтай	1,412,879,272
Ард секьюритиз	366,199,365

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	590.00	627,867
Таван толгой	7,200.00	379,189
МИК	12,990.00	269,014
Говь	337.18	236,038
Сүү	200.14	68,848

ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-18/07/20-A0275-15.14	400	41,160,000	101,510	104,290	156	15.140%
2	ZGEB-BD-25/04/20-A0236-16.993	30	3,060,000	102,000	102,000	156	16.993%

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.08.31	2018.09.10	2018.10.10-нд олгов
2	ERS	Монгол алт	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
3	TEE	Тээвэр дархан	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
4	TTL	Таван Толгой	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов
5	EER	Ариг гал	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с
6	BDL	Могойн гол	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	2018.06.26-нд олгов
7	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с
8	TAL	Талын гал	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор
9	BRC	Барилга корпораци	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
10	AND	Анд-Энерги	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
11	SUL	Жуулчин дюти фрий	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с
12	GTL	Гутал	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с
13	BNG	Баянгол зочид буудал	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с
14	APU	АПУ	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов
15	BTG	Баянтээг	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
16	MIE	Материалимпекс	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов
17	HRD	Хүрд	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор
18	SUU	Сүү	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов
19	MNP	Монгол шуудан	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов
20	MMX	Махимпекс	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с
21	TCK	Талх чихэр	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с
22	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	2018.03.06	2018.09.21-нд олгов
23	ADL	Адуун чулуун	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	2018.06.26-нд олгов
24	TAH	Тахь-ко	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
25	UBH	Улаанбаатар хивс	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с
26	GOV	Говь	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.12.21-нд олгов
27	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Түмэн шувуут” ХХК нээлттэй хувьцаат компани боллоо

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн А/94 тоот тушаалаар “Түмэн шувуут” ХК-ийн нэг бүр нь 20 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, нийт 200,000,000 ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлийн II ангилалд бүртгэснийг Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хурлаар хэлэлцэж, 373 тоот тогтоолоор нийт гаргасан хувьцааны 25 хувь буюу 50,000,000 ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар буюу нэгж хувьцааг 200 төгрөгөөр нийтэд санал болгон худалдахыг зөвшөөрсөн байна.

Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасаа олон нийтэд санал болгон гаргаж буй 2019 оны анхны компани болох “Түмэн шувуут” ХК нь нийт 10 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр анхдагч зах зээлийн сурталчилгааг эхлүүлээд байна.

Үнэт цаасны худалдан авах захиалгыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гишүүн бүх үнэт цаасны компаниудаар дамжуулан 2019 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс 1 дүгээр сарын 31-ний өдрийн 15:00 цаг хүртэл хүлээн авах бөгөөд худалдан авах захиалгыг МХБ-ийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын дагуу тогтсон үнийн аргаар авах юм.

Нийтэд санал болгож буй хувьцааны худалдан авах захиалгын хэмжээ нийлүүлэлтээс давсан тохиолдолд суурь хуваарилалт буюу нийт захиалга өгсөн хүний тоонд тэнцүү хуваан олгох дүнг 3 тэрбум төгрөгөөр тооцож, үлдэх 7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаасыг нийт захиалгын мөнгөн дүнтэй харьцуулан хувь тэнцүүлэн хуваарилна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Говь” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Говь” ХК нь 2017 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 220 төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэж, ногдол ашгийг 2018 оны 4 сарын 24-ний өдрөөс эхлэн компани дээрээ олгож байсан бол “ҮЦТХТ” ХХК-тай 2018 оны 12 сарын 21-ний өдөр байгуулсан гэрээний дагуу 2017 оны ногдол ашгийн үлдэгдэл болох 15,960 хувьцаа эзэмшигчдийн 800,789 ширхэг хувьцаанд ногдох 158,371,774 төгрөг /ХАОАТ суутгасан дүн/, мөн 2010-2016 онуудад зарласан ногдол ашгийн үлдэгдлийг хувьцаа эзэмшигчдийн дансанд 2018 оны 12 сарын 27-ны өдөр байршуулсан байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны сүүлийн ээлжит хуралдаан болж өнгөрлөө

Санхүүгийн зохицуулах хороо 2018 оны сүүлийн ээлжит хуралдаанаа 2018 оны 12-р сарын 26-ны өдөр хийлээ.

Хуралдаанаар, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасны дагуу “Үнэт цаас барьцаалах тухай” журмыг баталлаа. Энэ журмаар, үнэт цаасны зах зээлд оролцож буй иргэн, хуулийн этгээд өөрийн эзэмшил дэх үнэт цаасыг барьцаанд тавих, үнэт цаасыг тусгаарлуулах, барьцааны тухай мэдэгдлийг цахим мэдээллийн санд бүртгүүлэх, үүргийн гүйцэтгэлтэй холбоотойгоор барьцаалагч, барьцаалуулагч, гуравдагч этгээдийн хооронд үүссэн харилцааг зохицуулахаар журамласан байна.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

МХБ: Өдрийн дундаж арилжаа өмнөх оноос 21.5 хувиар өсч, 373 сая төгрөгт хүрсэн

Монголын хөрөнгийн биржийн өдрийн дундаж арилжаа өмнөх оноос 21.5 хувиар өсөж, 373 сая төгрөгт хүрлээ. Энэ нь сүүлийн таван жилийн хугацаанд тогтмол өссөн үзүүлэлт болж байгаа юм.

Өөрөөр хэлбэл 2014 онд Монголын хөрөнгийн биржид хийгдэж байсан өдрийн дундаж арилжааны дүн 95 сая төгрөг байсан аж. Үүнээс хойш жил бүр дундажаар 40 орчим хувиар өсч иржээ. Энэ онд хувьцааны арилжаа нэмэгдэхэд олон шинэ бүтээгдэхүүн гарч, анхдагч зах зээлийн арилжааны идэвх өссөн нь голлон нөлөөлсөн байна. Мөн энэ онд хийсэн өндөр дүнтэй хувьцааны анхдагчийн арилжаанаас “Мандал даатгал” компанийн 7.5 тэрбум төгрөг, “Монгол базальт” компанийн 6.4 тэрбум төгрөгийн арилжааг хийжээ. Жил гаруйн өмнөөс ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа зогссонтой холбоотойгоор хөрөнгө оруулагчид хувьцаа сонирхох хандлагатай байна гэж үнэт цаасны компаниуд онцолж байсан юм.

Эх сурвалж: BloombergTv.mn



БНХАУ-ын хөрөнгийн зах зээл 2.3 их наяд ам.долларын алдагдал хүлээж, хамгийн тааруу үзүүлэлттэй зах зээлээр нэрлэгдэв

БНХАУ-ын хөрөнгийн зах зээл тааруу жилийг үдэж байна. Дэлхийн хоёр дахь том хөрөнгийн зах зээлийн үнэлгээ “Худалдааны дайн”-ы нөлөөгөөр 2.3 их наяд ам.доллараар буураад байгаа аж.

Энэ нь 2002 оноос хойших хамгийн их алдагдалд тооцогдож байна. Үүний дотор тус улсын хөрөнгийн зах зээлийн гол индекс болох “Shanghai Composite” индекс сүүлийн нэг жилд 25 хувиар буурчээ.

Улмаар оны хамгийн тааруу үзүүлэлттэй Хөрөнгийн биржээр нэрлэгдэж байна. 10 жилийн өмнө дэлхийн санхүүгийн хямралын үеэр Шанхайн Хөрөнгийн биржийн индекс 65 хувиар буурч байсан юм. Түүнчлэн хөрөнгө оруулагчдын идэвх сүүлийн жилүүдэд байгаагүйгээр суларсан байна. Шанхай болон Шенжений Хөрөнгийн бирж дэх нэг өдрийн арилжааны дундаж дүн энэ онд 369 тэрбум юань буюу 54 тэрбум ам.доллар болж буурчээ. Энэ нь 2014 оноос хойших хамгийн доод үзүүлэлт болж байгаа аж.

Пүрэв гарагийн байдлаар 263.8 тэрбум юаниар хэмжигдэх хувьцаа арилжаалагдсан нь 2015 онд түүхэн дээд түвшинд хүрсэн үзүүлэлтийн 10 хувьтай л тэнцэх дүн болсон байна.

Үүнээс гадна БНХАУ-ын хөрөнгийн зах зээлд шинээр IPO хийсэн компаниудын хувьцаа арилжаагаа эхлүүлсэн эхний сардаа дундажаар 193 хувиар өсчээ. Энэ нь тийм тааруу дүн биш ч сүүлийн таван жилийн доод түвшин төдийгүй хоёр жилийн өмнөхтэй харьцуулахад дөнгөж 50 хувьтай нь тэнцэх үзүүлэлт гэж шинжээчид онцолж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ХХААХҮЯ: Мах, махан бүтээгдэхүүний экспорт 20 жилийн дээд түвшинд хүрлээ

Мах, махан бүтээгдэхүүний экспортын нийт хэмжээ 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 54.9 мянган тонн хүрсэн байна. Энэ нь “Сүүлийн 20 жилийн дээд хэмжээ” гэж Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам мэдээллээ.

Тоо толгойгоор нь авч үзвэл 2018 онд 4.4 сая толгой малтай тэнцэх хэмжээний мах, махан бүтээгдэхүүн экспортолжээ. Бэлчээрийн даац, сүргийн эргэлтийг харгалзаж жилд 180 орчим мянган тонн мах экспортлох боломжит нөөц байгаа гэж салбарын яам үзэж байгаа юм. Бизнесүүдийг авч үзвэл дотоодын 19 компани мах, махан бүтээгдэхүүн экспортлох эрхтэй байна. Тухайлбал, “Хатансүх импэкс” ХХК БНХАУ-д дулааны аргаар боловсруулсан бүтээгдэхүүн, БНСУ-д ясны шөл экспортолж байгаа талаар мэдээллээ. Мөн “Очирдагинас” ХХК БНСУ-д нөөжилсөн бүтээгдэхүүн экспортолж эхэлсэн байна. Компани 2018 оны 3-р сард хиам, консервын шинэ үйлдвэрээ ашиглалтад оруулсан гэж мэдээллээ. Хөдөө аж ахуйн салбар эдийн засгийн гол тулгуурын нэг болох боломжтой гэж зарим шинжээчид үзэж байна.

2018 онд “Ноолуур” хөтөлбөрийн хүрээнд Хөгжлийн банкны эх үүсвэрээр эргэлтийн хөрөнгийн зориулалтаар 20 үйлдвэрт нийт 188.2 тэрбум төгрөгийн зээл олгожээ. Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан үйлдвэрүүдийн самнах, ээрэх, сүлжих үйлдвэрлэлийн хүчин чадал 28-43 хүртэл хувиар өссөн байна.

Мөн Засгийн газраас энэ долоо хоногт баталсан Эрчимжсэн мал аж ахуй үндэсний хөтөлбөрт нийт 166.3 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна. 2019-2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн дүнд шингэн сүүний импортыг тэглэж, өндөгний импортыг 90 хувь, зөгийн балын импортыг 70 хувь бууруулах зорилт тавьсан ажээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

Уул уурхайн компаниудын хэлцлийн дүн 5 жилийн дээд цэгт хүрч, 86.3 тэрбум ам.доллараар хэмжигдэж байна

2018 он гарснаас хойш олон улсын хэмжээнд уул уурхайн салбарт 1,349 хэлцэл хийгдсэн байна. Эдгээрийн нийт үнэлгээ нь 86.3 тэрбум ам.доллар болсон нь 2017 оныхтой харьцуулахад 60 хувиар өссөн дүн болжээ. Мөн сүүлийн 5 жилийн хамгийн өндөр үзүүлэлтэд тооцогдож байна. БНХАУ-ын супер мөчлөгийн үед буюу металлын эрэлт огцом өсч байх онуудад уул уурхайн салбарын нэгдэн нийлэх хэлцлийн дүн 100 тэрбум давж байсан. Тухайлбал 2012 онд 149 тэрбум болж оргил цэгтээ хүрч байжээ. Харин 2015 онд зэс, алт, төмрийн хүдэр гэсэн гол түүхий эдийн ханш олон жилийн доод түвшинд хүрэхэд уул уурхайн компаниуд шинэ бизнес худалдан авна гэхээс илүү зардлаа танаж, ногдол ашгаа тараахад анхаарч эхэлсэн. Тухайн үед хэлцлийн дүн 50 тэрбум хүрч буурсан байна.

“Barrick Gold” компани “Randgold Resources”-той 5.4 тэрбум ам.долларын гэрээ хийсэн нь 2018 оны уул уурхайн салбарын хамгийн өндөр дүнтэй нэгдэн нийлэх хэлцэлт тооцогдож байна

Эх сурвалж: BloombergTv.mn

Нүүрсний үнийн өөрчлөлт гадаад худалдааны нөхцөлийн индексийг 11 хувиар доош татав

11-р сарын статистик мэдээлэлд тулгуурлан тооцсон Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индекс өмнөх сараас буурч, 1.731-д хүрсэн талаар Монголбанк мэдээллээ.

Энэ бууралт нь чулуун нүүрсний үнэ олон улсын зах зээлд буурсантай зэрэгцээд дотоодын экспортын нүүрсний үнэд нөлөөлсөнтэй холбоотой гэж үзэж байна. Тухайлбал, чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 11 дүгээр сард тонн нь 74 ам.долларт хүрсэн нь өмнөх сараас найман хувиар буурсан ч өнгөрсөн оны мөн үеэс таван хувиар өсжээ. Хэдийгээр гадаад худалдааны нөхцөлийн индекс сарын дүнгээр буурсан ч жилийн дүнгээр таван хувиар өссөн болохыг Монголбанк мэдээллээ.

Монгол Улс 2018 оны эхний 11 сарын хугацаанд 33.3 сая тонн нүүрсийг 2.6 тэрбум ам.доллараар экспортолсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад үнийн дүнгийн хувьд 24 хувиар, тоо хэмжээгээр есөн хувиар өссөн байна. Энэ оны хувьд чулуун нүүрсний экспортын үнэ 5, 6 дугаар сард буурч байсан бол долоодугаар сард бага зэрэг өсөж, наймдугаар сард буурч байжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn



ХААБ: 2018 онд 20 төрлийн түүхий эдийг 700 тэрбум төгрөгөөр арилжаад байна

Энэ онд ХААБ-ээр дамжуулан 20 төрлийн түүхий эдийг 700 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

Энэ нь өмнөх оноос 22.7 хувиар өссөн үзүүлэлт болж байгаа юм. Түүхий эдүүдийн үнэ энэ онд 30-70 хүртэлх хувиар өссөн нь арилжааны дүн нэмэгдэхэд нөлөөлсөн гэж ХААБ мэдээллээ. Мөн энэ онд хийсэн нийт арилжааны 82.3 хувийг боловсруулаагүй цайвар болон бараан ноолуурын арилжаа бүрдүүлсэн. Эдгээр түүхий эдийн үнэ өмнөх оноос 60 гаруй хувиар өссөн байна. Цаашдаа малчид ноолуурын чанартаа илүү анхаарч дотоодын үйлдвэрлэгчдэдээ нийлүүлэх, мөн боловсруулж, нэмүү өртөг шингээж экспортлох шаардлагатай байгааг салбарынхан онцолж байгаа. Энэ онд биржээр дамжуулж зөвхөн ноос ноолуурын арилжаагаар зогсохгүй малчдын хоршоо, арьс ширний үйлдвэр, махны үйлдвэр, худалдаа, нийтийн хоолны байгууллагуудын эрэлт нийлүүлэлт, нөөцийн судалгааг гаргаж, мал нийлүүлэх захиалгыг малчдын хоршоодод өгч, махны үйлдвэрүүдэд нийлүүлсэн. Ирэх онд ч мөн мал, мах, арьс шир худалдах, худалдан авах талуудын захиалгын дагуу форвард арилжаа зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

Засгийн газрын гадаад өр III улирлын байдлаар 7 тэрбум 24 сая ам.доллар хүрчээ

Монгол Улсын Засгийн газрын гадаад өр III улирлын байдлаар долоон тэрбум 24 сая ам.долларт хүрсэн гэж Монголбанк мэдээллээ. Энэ нь жилийн дүнгээр 12 хувиар өссөн үзүүлэлт болж байна. Засгийн газрын өрийн үлдэгдэл 2017 оны жилийн эцсийн байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 74.4 хувьд хүрч байсан юм. Энэ дүн 2018 оны эхний хагаст буурч дотоодын нийт бүтээгдэхүүний 58.9 хувь болжээ.

2019 онд Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийг дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан харьцаа нь 55.3 хувьд хүрэх төлөвтэй байгаа гэж Сангийн яам мэдээлээд байгаа юм. Мөн хүүний зардал 285.1 тэрбум төгрөгөөр буурна гэж үзжээ. Засгийн газар ирэх онд гадаадын зээл, тусламжийн хүрээнд 1.3 их наяд төгрөг ашиглахаар тооцоод байна. Засгийн газрын өрийг бүтцээр нь авч үзвэл урт хугацаат бонд, өрийн бичиг эзэлж байгаа ажээ.

Хүлээгдэж буй томоохон төлбөрүүдийг авч үзвэл "Синдикат" зээл 2021 онд, "Мазаалай" бонд 2021 онд, "Чингис" бонд 2022 онд зэрэг нийт 5.4 орчим тэрбум ам.доллар төлөх хуваарьтай байгаа юм.

Үүнээс гадна Төв банк гадаад валютын нөөцийг цаашид тууштай нэмэгдүүлэх чиглэлд ажиллахаа мэдэгдээд байна. 10-р сарын байдлаар гадаад валютын албан нөөц сүүлийн зургаан жилийн дээд түвшин буюу 3.4 тэрбум ам.долларт хүрээд байна. Засгийн газар өрийн менежмент хийх асуудлаар ажиллаж байгаа гэж мэдээлсэн юм.

Энэ онд "S&P" агентлаг Монгол Улсын урт хугацааны эзэлжих зэрэглэлийг "B" болгон дээшлүүлж, төлөвийг "Тогтвортой" хэвээр хадгалаад байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

Тавантолгойн станц 2023 онд ашиглалтад орно

Засгийн газрын ээлжит хуралдаан 2018 оны 12-р сарын 26-ны өдөр боллоо.

Тавантолгойн ордыг түшиглэн Оюутолгойн төслийг эрчим хүчээр хангах цахилгаан станц барих тухай гэрээнд гарын үсэг зурах эрхийг сайд Ц.Даваасүрэн, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга А.Тлейхан нарт олгохоор болов.

Энэ хүрээнд 300 МВт хүчин чадалтай Тавантолгойн дулааны цахилгаан станц барьж, Оюутолгой төслийн төв дэд станцтай 220 кВ-ын хоёр хэлхээтэй цахилгааны шугамаар холбоно. Цаашид хүчин чадлыг нь өргөтгөх боломжтой байх юм байна. Барилгын ажлыг 2020 оны 3-р сард эхэлж 2023 оны 6-р сарын эцэс гэхэд дуусгах, санхүүжилтийг "Тавантолгойн цахилгаан станц" компанийн Хөрөнгө оруулалтын гэрээгээр зохицуулахаар гэрээнд тусгажээ.

"Оюутолгой" компани ирэх оноос эхлэн цахилгаан эрчим хүчээ боломжит хэмжээгээр манай улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс авахаар тохиролцоод байна гэж Засгийн газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсээс мэдээллээ.

Эх сурвалж: MongolianMiningJournal.com



Ам.долларын ханшийн жилийн өсөлт сүүлийн 3 жилийн дээд түвшинд хүрлээ

Ам.доллар сүүлийн гурван жил орчмын хугацаан дахь хамгийн сайн үзүүлэлттэйгээр 2018 оныг үдэж байна. 2017 онд ам.долларын индекс 10 гаруй хувиар унаад байсан ч энэ онд "Худалдааны дайн" үргэлжилж, юанийн ханш огцом суларснаар ам.долларын хувьд 2018 он таатай жил байлаа. "Factset"-ийн тооцооллоор ам.долларын ханш таван хувиар чангарсан байна. Хэдий тийм боловч валютын захын шинжээчид 2019 онд ам.доллар амжилтаа давтаж чадахгүй гэж үзэж байна. Тодруулбал, эцэслэн шийдэгдээгүй байгаа ч худалдааны асуудлаас аль нэг тал хохирох биш, харилцан буулт хийснээр бүх зах зээлд ашигтай тохиролцоо хийх төлөв харагдаж эхэлснийг ажиглагчид онцолж байна. Гэхдээ тохиролцоо хийх хүртэл хоёр тал дахин дахин зах зээлд хүчтэй нөлөө үзүүлэхүйц мэдэгдэл хийж магадгүй гэсэн хүлээлт байгаа учраас оны эхэнд ам.долларын ханш эмзэг байхыг мөн анхааруулжээ.

Тиймээс фючерс хэлцэл болон хэдхэн хийх арилжигчид шинэ оны эхний улирлаас цааш позици эргэн харах шаардлагатайг "State Street Global Investors"-ийн ахлах портфолио менежер Аарон Хурд онцолсон байна.

Түүнчлэн АНУ-ын Холбооны Нөөцийн банк бодлогын хүүгээ алгуур боловч эргэлт буцалтгүйгээр нэмж байгаа нь ам.долларын хүчийг цаашид сулруулах төлөвтэй байна. Холбооны Нөөцийн банкны тэргүүн Жером Пауэллын сүүлийн мэдэгдэл ирэх онд хоёр удаа бодлогын хүүг нэмж өсгөнө гэсэн дохио өгсөн юм. Энэ онд тус банк бодлогын хүүгээ дөрвөн удаа өсгөөд байна.

Үүнээс гадна АНУ-ын худалдаа болон төсөв "хосолсон" гэгдэж байгаа алдагдалтай байгаа нь төдийлөн эерэг мэдээлэл болохгүй. Бүсчлэн авч үзвэл Евро бүсэд ам.доллар хамгийн сул байх төлөвтэй байна. Учир нь европчуудын ам.долларт итгэх итгэл АНУ болон Азийн хөрөнгө оруулагчдаас ямагт бага байж ирсэн аж. Нөгөө талаас сул ам.долларын ханш 2018 онд эдийн засгийн тааруу үзүүлэлтүүд болон BREXIT-ээс үүдэн 5.6 хувиар унаад байгаа еврод ирэх онд "өндийх" боломж олгоно гэж харж болохоор байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

мэдэгдэл

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.